



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2021 оны 09 сарын 24 өдөр

Дугаар 398

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 148 дугаар тогтоолын 1.6 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1.2, 4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2019, 2020 онд Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын багцаас санхүүжүүлэн барьж ашиглалтад оруулсан нийт 332,385,755.00 (гурван зуун гучин хоёр сая гурван зуун наян таван мянга долоон зуун тавин таван) төгрөгийн үнэ бүхий барилга, байгууламжийг хавсралтад заасны дагуу Өвөрхангай, Завхан, Ховд аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвд эзэмшүүлж бүртгэлд тусгахыг зөвшөөрсүгэй.

2. Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Ганболд, Өвөрхангай, Завхан, Ховд аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн дарга нарт тус тус дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Комисс томилон хөрөнгө хүлээн авч, бүртгэх ажлыг холбогдох хууль тогтоомж журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2021 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-г үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

133001316

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
 2021 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн
 298 дугаар тогтоолын хавсралт

Байгаль, орчин аялал жуулчлалын яамны харьяа Ус, цаг уур орчны шинжилгээний төвүүдийн үндсэн хөрөнгөд бүртгэх үл хөдлөх хөрөнгийн жагсаалт

Д/д	Төсөл, арга хэмжээний нэр, байршил	Барилгын хүчин чадал	Гүйцэтгэлээрх дүн /тегерегээр/	Улсын комиссын актын дугаар	Эзэмших байгууллагын нэр
1	Цаг уурын станцын барилга /Өвөрхангай аймаг Богд сум/	1 давхар, 61.506 м ²	96,590,958.00	БУ-25/2019	Өвөрхангай аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төв
2	Цаг уурын өртөөний барилга /Завхан аймаг Тосонцэнгэл, Нөмрөг сум/	1 давхар 85,9 м ² 1 давхар 85,9 м ²	144,987,560.00	19/2017 21/2020	Завхан аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төв
3	Цаг уурын өртөөний барилга /Ховд аймаг Мөст сум/	1 давхар 70 м ²	90,807,237.00	A/27/2020	Ховд аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төв
	Нийт дүн		332,385,755.00 (гурван зуун гучин хоёр сая гурван зуун наян таван мянга долоон зуун тавин таван төгрөг)		